Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар

# УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний
83 хувь нь хэрэгжсэн байна.

## Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих орон нутагт эрх шилжүүлсэн 6 төсөл, арга хэмжээ батлагдсан



**4**
**Өмнөх оноос дамжин хэрэгжих**



**2**
**Шинээр хэрэгжүүлэх**

**1**
**төсөл, арга хэмжээг**

Төсвийн тухай хуулийн 29.3.5 “Хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” заалттай нийцүүлж төлөвлөөгүй байна.

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛСЭН САНАЛ

ХББОС-ын сайдын 2025 оны төсвийн XVIII.1.1 багцад туссан төсөл арга хэмжээний санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай уялдуулж тэнцүү хуваарилж төлөвлөх талаар төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлан дүгнэлтэд тусгах.

# ЗАХИАЛАГЧААС АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭГ ХҮРГҮҮЛЭХДЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗААСАН ХУГАЦААГ БАРИМТЛААГҮЙГЭЭС ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУГАЦААНД НЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОМЖГҮЙ БОЛСОН БАЙНА.

**2025 онд шинээр хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээ**

**! Захиалагч нь ажлын тоо хэмжээг төлөвлөгөөнөөс хоцроосон хоног**

“Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/”

“Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/”




! Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанаас хоцроон **shilendans.gov.mn** цахим системд байршуулсан байна.

✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан 5 сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

✓ Худалдан авах ажиллагааны явцад гомдол гараагүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 83.0 хувь нь хэрэгжсэн ч техникийн хяналт хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.




Хөрөнгийг бүрэн бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж байна.

## <u>АУДИТААР ӨГӨГДСӨН ШИЙДВЭР:</u>




Төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан хүргүүлэх, мэдээллийн самбарыг стандартын дагуу байршуулах талаар холбогдох хуульд заасан захиалагчийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах **1 ЗӨВЛӨМЖ**




**2** төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан гаргаагүй, фото зургаар баримтжуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх **1 АЛБАН ШААРДЛАГА -ыг** АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-д хүргүүлсэн.